



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/574

Арвайхээр

“Малчдын бүсийн зөвлөгөөн” зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн, 29.1.3.“а”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Малчдын бүсийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулах хугацаа, хуваарийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Малчдын бүсийн зөвлөгөөнд сум бүр 30 малчин оролцуулахаар тооцож малчдыг нэгдсэн унаагаар тээвэрлэж, аюулгүй байдлыг бүрэн ханган зохион байгуулалттай оролцохыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.“Малчдын бүсийн зөвлөгөөн” зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, сумдад мэдээлэл хүргэж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-д даалгасугай.

4.Хавсралтад тусгагдсан 17,606,750 (арван долоон сая зургаан зуун зургаан мянга долоон зуун тавь) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

011101218

Аймгийн Засаг даргын 2021 оны...¹¹
дугаар сарын ...¹⁷...ны өдрийн...^{17/574}
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт



**“МАЛЧДЫН БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨН”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХУГАЦАА, ХУВААРЬ**

Д/д	Зөвлөгөөн зохион байгуулагдах сумдын нэр	Оролцох сум	Зохион байгуулагдах хугацаа
1.	Есөнзүйл	Бүрд, Баян-Өндөр, Сант, Өлзийт	2021-11-28
2.	Хужирт	Уянга, Бат-Өлзий, Хархорин, Зүүнбаян-Улаан	2021-12-11
3.	Гучин-Ус	Баянгол, Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан	2021-12-13
4.	Хайрхандулаан	Нарийнтээл, Тарагт, Арвайхээр	2021-12-14

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн 1574 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



“МАЛЧДЫН БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨН”-НИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Өдрийн хоол	Порц	825	10000	8250000
2	Анонс	M2	35	12000	420000
		M2	72	14000	1008000
3	Урлагийн тоглолтын зардал	ш	4	900000	3600000
4	Эрчимжсэн мал аж ахуй, тэжээлийн талаар лекц унших 2 эрдэмтний ажлын хөлс	2 хүн	2	1000000	2000000
5	Эмнэлгийн үзлэг хийх эмч нарын томилолтын зардал	5 хүн / 5 өдөр	25	26500	662500
6	Архив, Улсын бүртгэл, урлаг, хэвлэл мэдээлэл, эмч нарын машины шатахууны зардал	л	775	2150	1666250
	Нийт зардал				17606750

-oOo-